

ТЕЛЕВИЗИЙН ТАНИН МЭДЭХҮЙН НЭВТРҮҮЛГИЙН ҮҮРЭГ, АЧ ХОЛБОГДОЛ

Б.Оюунгэрэл*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн магистрант

Түлхүүр үгс: Танин мэдэхүйн боловсрол, шинжлэх ухааны нэвтрүүлэг, танин мэдэхүй, телевизийн нэвтрүүлэг, сэтгүүл зүйн соён гэгээрүүлэх үүрэг.

Манай оронд телевизийн танин мэдэхүйн хөтөлбөр болоод шинжлэх ухааны сэтгүүл зүйн талаарх судалгааны тоо сүүлийн жилүүдэд нэмэгджээ. Сэтгүүл зүйн соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх үүргийн тухай тэр дундаа телевизийн танин мэдэхүйн нэвтрүүлгийн чанар, хүртээмжийн асуудлыг хөндсөн бакалавр болон магистрын зэрэг горилсон хэд хэдэн судалгааны ажил хийгдсэн байна. Нөгөөтээгүүр, олон улсын хэмжээнд телевизийн танин мэдэхүйн болон цэнгээнт нэвтрүүлэг нь нас насныхны тархины хөгжил, зан байдалд хэрхэн нөлөөлдөг тухай маш олон судалгаа бий.

Нийгмийн хурдацтай дэвшил, хүмүүсийн амьдралын хэв маяг өөрчлөгдөж байгаатай уялдуулан шинжлэх ухааны сэтгүүл зүй, сэтгүүл зүйн танин мэдэхүйн агуулга бүхий бүтээлийн ач холбогдол, хэрэгцээ шаардлага нэмэгдэж байгаа нь энэ сэдвийг судлах зайлшгүй шаардлага үүссэнийг харуулж байгаа юм. Энэхүү өгүүлэлд шинжлэх ухаан, танин мэдэхүйн нэвтрүүлгийн

нийтэд хүртээх ач тус болон энэ төрлийн нийтлэл, нэвтрүүлгүүд үзэгчдийн хүсэл шаардлагад нийцсэн эсэхийг хэвлэл мэдээллийн байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, судалгаанд үндэслэн тайлбарлаж, энэ цаг үед үзэгчдийн хүртээл болж буй зарим нэвтрүүлгийн агуулга, хэлбэрийг задлан шинжилж, нэгтгэн дүгнэхийн хичээсэн болно.

Телевизийн танин мэдэхүйн нэвтрүүлгийн үүрэг, ач холбогдол: Манай орны сэтгүүл зүйн суурь нь шинжлэх ухааны мэдээ мэдээлэлтэй нягт холбоотой. Учир нь монголын хамгийн анхны тогтмол хэвлэл болох “Шинэ толь хэмээх бичиг” сонинд өдөр тутмын үйл явдал, засаг төрийн бодлого шийдвэрийг мэдээлэхээс гадна дэлхийн сонин хачин, элдэв шинжлэх ухааны хялбаршуулсан өгүүлүүдийг тогтмол нийтэлдэг байсан тухай сэтгүүл зүй судлаачид дэлгэрэнгүй тэмдэглэсэн байдаг.

Орчин үеийн цахим хөгжил, технологийн дэвшил, чиг хандлага мэдээлэл харилцаа холбооны салбар дахь өөрчлөлт, шинэчлэлт зэргээс хамааран хүлээн авагчдын хэрэгцээ, сонирхол өөрчлөгдсөөр байна. Үүнээс улбаалан хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийтлэл, нэвтрүүлгийн агуулга

хэлбэрээ хүлээн авагчдын сонирхол, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн бүтээх зайлшгүй шаардлага үүссэн.

Орчин цагийн хүмүүст хүрээлэн буй орчин, шинжлэх ухааны хөгжил, түүний өдөр тутмын амьдралд үзүүлж буй нөлөөлөл зэргийг цаг алдалгүй, түргэн шуурхай хүлээн авч байх нь нэн чухал болсон. Уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дундаас хамгийн хурдацтай бөгөөд сонирхолтой, өгөөжтэй хэлбэрээр мэдээлэл дамжуулж чадах нь телевиз юм. Хэдийгээр цахим технологийн хөгжил нүд ирмэхийн зуур хувьсан хөгжиж байгаа боловч хүмүүсийн өдөр тутмын амьдралын хэв маягт телевизийн эзлэх байр суурь хэвээр байгаа билээ.

Мэдээлэл хүлээн авах эсэх нь хувь хүний сонголтоос хамаардаг болсон орчин үед телевизийн гүйцэтгэх үүрэг нь шуурхай мэдээлэхээс илүүтэй зугаацуулах, танин мэдүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлд түлхүү хөгжиж байна. Ингэж үзэж байгаагийн учир нь мэдээллийн ертөнцөд цахим сайт хүч түрэн орж ирснээр яг одоо өрнөж байгаа үйл явдлыг хүсэх л юм бол гар утас болон бусад овор хэмжээ багатай төхөөрөмжүүдийг ашиглан хаа байгаа газраасаа бичвэр, дуу эсвэл дуу дүрсний хамтаар хүлээн авах боломж хэдийн бүрдсэнтэй холбоотой юм.

2013 оныг хүртэл иргэдийн мэдээлэл хүлээн авах хамгийн гол хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь телевиз байсан бөгөөд 2015 оноос энэ байдалд эрс өөрчлөлт гарч интернэтийн хэрэглээ улсын хэмжээнд нэмэгдсэн тухай хэвлэлийн хүрээлэнгээс 2015 онд хийсэн “Хэвлэл мэдээллийн хэрэглэчийн судалгаа” -нд дэлгэрэнгүй дурдсан (МХХ, 2015) байна. Энэ нь орчин үеийн

хүлээн авагчид аливаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулж буй мэдээллийг сонголтгүйгээр шууд хүлээн авахаа больж, өөрийн эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн мэдээллийг сонгож үздэг болсныг харуулж байна.

Хүлээн авагчид сэтгүүл зүйн салбараас боловсруулсан, задлан шинжилсэн, сонирхолтой бүтээл хүлээдэг болсон. Үүний нэг илрэл нь шинжлэх ухаан, танин мэдэхүйн бүтээлийн эрэлт хэрэгцээ юм. "Танин мэдэхүйн

үүрэг нь нийтлэл, нэвтрүүлэг дэх танин мэдэхүйн элементийн хэр хэмжээгээр тодорхойлогдох бөгөөд чухам үүргээр дамжин материалын үнэ цэн, ач холбогдол тодорхойлогдоно. Мэдээ, нийтлэл, нэвтрүүлэг болгон ун-шигч, сонсогч, үзэгчдийн танин мэдүүлэх зөв чиглэлд хөтлөн, бүх юмны учрыг олох гэсэн хүн төрөлхтний хүсэл эрмэлзэлд тус нэмэр болж байх үүрэг-тэй". (Зулькафиль, 2004) Олон нийтийн



Мэдээлэл хүлээн авах эсэх нь хувь хүний сонголтоос хамаардаг болсон орчин үед телевизийн гүйцэтгэх үүрэг нь шуурхай мэдээлэхээс илүүтэй зугаацуулах, танин мэдүүлэх, соён гэгээрүүлэх чиглэлд түлхүү хөгжиж байна. Ингэж үзэж байгаагийн учир нь мэдээллийн ертөнцөд цахим сайт хүч түрэн орж ирснээр яг одоо өрнөж байгаа үйл явдлыг хүсэх л юм бол гар утас болон бусад овор хэмжээ багатай төхөөрөмжүүдийг ашиглан хаа байгаа газраасаа бичвэр, дуу эсвэл дуу дүрсний хамтаар хүлээн авах боломж хэдийн бүрдсэнтэй холбоотой юм



танин мэдэхүйн боловсролд чиглэсэн телевизийн дотоодын бүтээл үйлдвэрлэл сүүлийн жилүүдэд буурсаар байгаа. Танин мэдүүлэх, соён гэгээрүүлэхээс илүү зугаацуулан цэнгүүлэх зорилго бүхий бүтээлийн тоо эрс нэмэгдэв. Телевизийн өөрийн үйл ажиллагаанд энэ нь ашигтай боловч танин мэдэхүйн бүтээл үйлдвэрлэл бага байх нь олон нийтийн боловсрол тэр дундаа шинжлэх ухааны анхан шатны мэдлэг, мэдээлэл дутмаг байхад тодорхой хэмжээнд нөлөө үзүүлж байна.

Манай оронд шинжлэх ухааны сэтгүүл зүй төдийлөн сайн хөгжөөгүйн дээр үүний ач холбогдлыг салбарынхан болоод хүлээн авагчид төдийлөн чухал гэж үзэхгүй байна. “Шинжлэх ухааны сэтгүүл зүй (Science journalism/Science communication) гэдэг бол сэтгүүл зүйн тусгай салбар бөгөөд шинжлэх ухааны баримт, мэдээллийн үндсэн утга санааг өөрчлөхгүйгээр ОНМХ-ийн энгийн, ойлгомжтой нийтлэлийн хэл рүү шилжүүлэх чиглэл юм. Шинжлэх ухааны сэтгүүл зүйг өргөн утгаар нь олон нийтэд шинжлэх ухааны ололт амжилт, түүний түүх, өнөөгийн байдал, хөгжлийн хэтийн төлөв, тулгамдсан асуудлуудын талаар энгийн ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэх сэтгүүл зүйн түгээмэл чиглэл гэж ойлгож болно” (Зулькафиль, 2020). Шинжлэх ухааны мэдээ мэдээллийг дундаж хүлээн авагчийн хэмжээнд боловсруулан түгээх нь сэтгүүлч болон редакцын зүгээс ихээхэн хүчин чармайлт, мэдлэг, мэдрэмж шаардах боловч үүний үр өгөөж нь улс орны хэмжээнд яригдахуйц их юм.

2020 оны байдлаар тогтвортой үйл ажиллагаа явуулж буй телевизийн сувгуудаас рейтингээрээ эхний 20-д

багтсан сувгуудын хамгийн их үзэлттэй байсан бүтээлүүдийг харвал:

- “Боловсрол” телевизийн “Бүтэн амьдрал” ОАУСК
- “Монгол HD” телевизийн “The voice of Mongolia” шоу
- “Боловсрол” телевизийн “Бурхны авралаар чи ирлээ” шоу
- “С1” телевизийн “Инээдээр дархлаагаа дэмжье” зэрэг зугаацуулах хэв маяг бүхий бүтээлүүд байсан тухай “Максима консалтинг”-ийн 2020 оны “Телевиз үзэлтийн судалгааны тайлан”-нд (Максима, 2020) дурджээ. Үзэлтээрээ тэргүүлсэн телевизийн нэвтрүүлэг, бүтээл дунд танин мэдэхүйн шинж бүхий бүтээл байхгүй байгаа нь энэ төрлийн сонирхолтой, өгөөжтэй бүтээлийн орон зай үгүйлэгдэж байгааг харуулж байгаа юм. Үзэгчдийн анхаарлыг татаж байгаа бүтээлүүдийг зугаацуулах төрлийн нэвтрүүлэг, контент тэргүүлж байгаа боловч манай ОНМХ-үүд шинжлэх ухааны болон танин мэдэхүйн нийтлэл, нэвтрүүлгийг огт хийгээгүй бус өөрсдийн боломж, нөхцөл байдалд тааруулан хийж байгаа. Олон нийтийг хамарч, зорилтот хүлээн авагчдаа бүрэн хүрч чадахгүй байгаад бүтээлийн маркетингийн асуудал нөлөөлж байна. Шинэ бүтээлийг нэвтрүүлэхэд олон нийтийн анхаарлыг татаж, сонирхлыг нь өдөөж, хүлээлт үүсгэх нь орчин үед чухал болсон. Амжилттай маркетинг хийх урьдач нөхцөл нь зах зээлийн судалгаа хийх, зорилтот хэрэглэгчдийн онцлог, хэрэгцээ шаардлага зэргийг бодитойгоор судлан илрүүлж, түүнд нийцсэн бүтээл үйлдвэрлэхэд оршино.

Танин мэдэхүйн нэвтрүүлэг бол үзэгчдийн цагийг дэмий үрэх бус амарч, алжаалаа тайлангаа шинжлэх ухааны шинэ мэдээ мэдээлэлтэй танилцах, өөрийн сонирхсон сэдвийн дагуу илүү

шинжлэх ухаанч мэдлэгтэй болох зэрэгт туслах өгөөжтэй бүтээл юм. Сэдвийн тухайд хүрээлэн буй орчин, байгаль дэлхий, ургамал, амьтад, сансар огторгуй, шинжлэх ухааны шинэ нээлт, бодис, технологи гэх мэтчилэн хязгаарлагдамгүй олон.

Телевизийн шинжлэх ухаан танин мэдэхүйн нэвтрүүлэг, бүтээлийн агуулга нь ач холбогдолтойн дээр түүнийг сонирхолтой хэлбэрээр дамжуулж, зорилтот үзэгчдэд хүрснээрээ дараах ач холбогдолтой.

Хүлээн авагчдын сэтгэлгээний цар хүрээг тэлнэ. Юун түрүүнд үзэгчдийн хүсэл шаардлагад нийцсэн бүтээлийг бий болгох нь хэвлэл мэдээллийн байгууллагын амжилттай, тогтвортой үйл ажиллагаа явуулах үндэс суурь болдог. Аливаа шинжлэх ухааны мэдээ, мэдээллийг давтамжтайгаар хүлээн авснаар олон нийтийн боловсролын байдал болоод аливаа асуудалд хандах хандлагад ихээхэн өөрчлөлт гарна. Шинжлэх ухааны суурь мэдлэг дутмаг байхын хамгийн сөрөг тал нь эрүүл мэндийн асуудалд хандах хандлага юм. Аливаа өвчин эмгэгийг амнаас ам дамжсан буруу аргаар эмчлэх гэж оролдох, улмаар улам хүндрүүлэх зэрэг асуудал түгээмэл. Цахим орчин дахь эрүүл мэндийн бүлгэмүүдээс энэ байдал тодорхой ажиглагдаж байна.

Нийгмийн сэтгэл санаа, нөхцөл байдалд эерэг нөлөө үзүүлнэ. Нэвтрэх чанарт суурилсан телевизийн хамгийн чухал онцлог нь нийгмийн бодит дүр зураг, аж байдлыг шууд тусгах явдал. Тийм ч учраас тогтвортой, идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо нэмэгдэх тусам хандалт горилсон бүтээлийн тоо эрс нэмэгдсэн. Нийгэмд шуугиан, сенсац үүсгэх зорилго бүхий хар бараан, сэтгэл

эмзэглүүлэм мэдээллийн араас их хөөцөлдөж байна. Энэ байдлыг тэнцвэртэй, зохист хэмжээнд барих нь мэргэжлийн сэтгүүл зүйн үүрэг билээ. Сэтгүүл зүйн соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх үүрэг нь хүлээн авагчдын сэтгэлгээг тэлж, сэтгэлийг баясгах мэдээлэл байдгаараа онцлогтой. Сэтгүүл зүй судлаачид, уран бүтээлчид энэ салбарыг нийгмийн оюун санааны байдалд нөлөөлөх, тодорхойлох чадалтай гэж үздэг шалтгаан нь үүгээр илэрч байгаа юм. Түүнчлэн сэтгүүл зүйн бүтээлийн агуулга нь улс орны гадаад болон дотоод имиж бүрдүүлэлтийг бий болгодог. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр түгээж байгаа мэдээллийн агуулга олон нийтийн сэтгэл санаанд шууд болон дам хэлбэрээр нөлөөлөх нь дамжиггүй тул болгоомжтой, хянуур хандах нь зүй. Тиймээс шинжлэх ухаан, танин мэдэхүйн төрлийн нэвтрүүлэг, контент нь үзэгчдийн алжаалыг тайлж, сэтгэл санаанд нь эерэг нөлөө үзүүлэх нэг чухал хүчин зүйл юм.

У*ран бүтээлчдийн ур чадварыг дээшлүүлнэ.* Танин мэдэхүйн тэр дундаа шинжлэх ухааны сэдэв маш өргөн. Аль ч салбарын тухай хөндсөн байж болох бөгөөд үүнийг боловсруулж үзэгчдэд хүргэх үйл явц нь сэтгүүлчээс ихээхэн ур чадвар, бүтээлч байдал, мэдрэмж шаарддаг. Оюуны бүтээл үйлдвэрлэлийн салбарт ажиллагсдын хувьд сэдэв сонгохоос авхуулаад өөрийн болон хамтын бүтээлээ олон нийтийн хүртээл болгож, үр шимийг нь харах хүртэлх үйл явц нь тэр чигтээ ур чадвар шаарддаг онцлогтой. Нэн ялангуяа танин мэдэхүйн нийтлэл нэвтрүүлэг бэлтгэж, түүнийгээ нийтийн хүртээл болгох явц нь ихээхэн хүчин чармайлт шаардана. Энэ төрлийн бүтээлийг хүлээн авагч нас, боловсролын түвшин зэргээс үл

хамааран ойлгох, сонирхох агуулга хэлбэрээр бүтээх хэрэгтэй. Ингэж чадвал сая шинжлэх ухаан, танин мэдэхүйн бүтээлийн зорилго биелэх юм. “Шинжлэх ухааны нийтлэлүүдийн гол зорилго нь шинжлэх ухааны мэдлэгийг эргэлтэд оруулах, эрдэмтэн судлаачдыг судалгааны явцын болон үр дүнгийн талаарх мэдлэгээр хангах, нийгэмлэгийн доторх дотоод харилцааны үүргийг гүйцэтгэх замаар түүний бүтэц нэгжүүдийн харилцан уялдаа холбоог бэхжүүлэхэд нөлөөлж, нийгмийн институт болох шинжлэх ухааны үйл ажиллагааг хэвийн явуулах, хөгжлийн тогтвортой, нэгдмэл байдлыг хангахад оршино”. (Зулькафиль, 2021) Танин мэдэхүйн нэвтрүүлэг нь ихэнхдээ эхлэлээсээ төгсгөл хүртэл тодорхой нэг л сэдвийг өгүүлнэ. Тиймдээ ч хугацааны хувьд харьцангуй богино буюу 10-30 минут үргэлжилдэг. Маш бага хугацаанд хэт их мэдээллээр “бөмбөгдсөн” эсвэл хэт их мэргэжлийн үг хэллэг ашигласан, хэл найруулга муутай байх нь үзэгчдийн таашаалд нийцдэггүй, сувгаа солих нэг шалтгаан болдог.

“Телевизийн бүтээл хүний оюун санаанаас урган гарч, объектив, субъектив талуудтай нөхцөлдөн нөлөөллийг бий болгодог учраас шийдэл, агуулгын хувьд хязгааргүй, таамаглах аргагүй билээ”. (Өнөрсайхан, 2022) Шинжлэх ухаан, танин мэдэхүйн нэвтрүүлэг нь сэдэв, агуулга, хэлбэрээс хамааран ихэвчлэн 15-30 минутын хугацаатай байдаг. Баримтат бүтээл урт хугацаагаар үргэлжлэх хандлагатай. Богино хугацаанд үргэлжлэх тул үзэж дуусгахад төвөггүй мэт боловч агуулгыг нь сонирхолтой хэлбэрээр хүргэхгүй бол үзэгчид амархан уйдах талтай. Ялангуяа бага насныхны хувьд сонирхолтой анхаарал татсан, өнгөлөг байдал ихээхэн чухал. Жишээ болгон МҮОНТВ-

ийн “Том ахын аялал” байгаль, экологийн танин мэдэхүйн нэвтрүүлгийн агуулга, хэлбэрийг ерөнхийд нь товч дүгнэвэл:

Агуулгын тухайд байгаль дэлхийн бүтэц, монголчуудын эх дэлхийтэйгээ харилцаж ирсэн ёс уламжлал, гэрийн тэжээмэл болон зэрлэг амьтдын тухай өгүүлэх бага насны хүүхдүүдэд зориулсан танин мэдэхүйн нэвтрүүлэг юм.

Хэлбэрийн тухайд дунджаар 25-30 минут үргэлжилнэ. Олон талын сэдвийг багтаасан боловч нэвтрүүлгийн хийц, формат нь нэгэн хэвийн. Нэвтрүүлгийн гол дүрүүд хүүхдүүд боловч мэдээллийг насанд хүрэгчид дамжуулах ба насанд хүрэгчдэд зориулсан мэт үгийн сонголт, өнгө аястай байгаа нь зорилтот бүлэгтээ бүрэн хүрэхэд саад болжээ.

Сэтгүүл зүй судлаачид телевизийн хөтөлбөрийн агуулга, чанар нь тухайн улс орны хөгжлийн толь болдог гэж үздэг. Орчин үеийн хүлээн авагчдын хамгийн том онцлог нь өөрт хэрэгтэй мэдээллийг л сонгон хүлээн авч буй байдал юм. Өнгөрсөн үед телевизийн сүлжээгээр ямар агуулга, хийц бүхий мэдээ мэдээлэл, нэвтрүүлэг сэлт нэвтрүүлэхийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрөө шийдэж түүнийг нь олон нийт шүүлтүүргүйгээр хүлээн авдаг байсан. Орчин үед энэ байдал эрс өөрчлөгдөж, нээлттэй цахим орчноос өөрт хэрэгтэй мэдээллээ дурын хэлээрээ олж, ашиглах боломж бүрэн бий болсон. “Улсын болон олон нийтийн телевизийн нэг хэлбэрийн, хэт баригдмал өгөгдөл, арилжааны телевизийн мөнгө санхүү, дуулиан шуугиан хөөж, нийгмийн сөрөг талыг харуулах нь давамгайлсан нэвтрүүлгүүд үзэгчдийн шүүмжлэлийг дагуулах болсон” (Өнөрсайхан, 2019). Энэ дутагдлыг

цахим орчин дахь зарим бүтээлүүд нөхөх болов. Тухайлбал, Youtube-д идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хандалт ихтэй хэд хэдэн монгол сувгууд байна. Зөвхөн шинжлэх ухааны мэдээлэл дамжуулдаг “Gej Yu Ve?” сувгийг онцлон нэрлэж болно. Тухайн сувгийн хамгийн гол онцлог нь шинжлэх ухааны шинэ мэдээлэл, нээлт, хүн бүрийн мэдэх ёстой шинжлэх ухааны сэдэв, ойлголтуудыг хамгийн энгийнээр буюу хялбаршуулсан байдлаар тайлбарладаг оршино. Энэхүү сувгийн үйл ажиллагаа өргөжин олон нийтэд илүү хүртээмжтэй болсон. “Tenger” телевиз “Gej Yu Ve?” youtube сувагтай хамтран шинжлэх ухаантай холбоотой олон төрөл, сэдэв бүхий мэдээ, мэдээллийг бэлтгэн хүргэдэг “Билиг” шинжлэх ухаан, танин мэдэхүйн нэвтрүүлгийг баасан гараг бүр дамжуулж байна. Нэвтрүүлгийн хүрээнд тодорхой нэг сэдвийг онцлон тайлбарлаж, тухайн сэдэвтэй холбоотой судалгаа хийдэг эрдэмтэн судлаачидтай ярилцах ба төгсгөлд нь шинжлэх ухааны ертөнцөд өрнөж буй хамгийн сүүлийн үеийн мэдээ мэдээллийг тоймлон хүргэдэг нэвтрүүлэг юм. Телевиз болон боломжит цахим платформуудыг бүрэн ашигласнаар нэвтрүүлгийн хүртээмж илүү нэмэгдсэн байна.

Нийгмийн хөгжил, дэлхий дахины өөрчлөлт хувьслын нөлөөгөөр хүн төрөлхтний мэдээлэлд хандах хандлага, хэрэгцээ шаардлага өөрчлөгдсөөр байна. Мөн мэдээллийн шинэ технологи, цахим хөгжлийн нөлөөгөөр салбар бүрд шинэ чиглэл бий болж, зарим тохиолдолд уламжлалт хэлбэр нь хэрэглээнээс гарч байна.

Мэдээллийн технологийн хөгжил нь сэтгүүл зүйд олон өөрчлөлт авч ирсэн. Хэвлэл мэдээллийн байгуулла-

гууд нийтлэл, нэвтрүүлгийн агуулга хэлбэртээ шинэ арга барил нэвтрүүлэн, нийтийн түгээмэл хэрэглэдэг платформуудаар түгээх болсон. Энэ нь бүтээлийн хүртээмж нэмэгдэхэд ихээхэн түлхэц болдог.

Манай орны сэтгүүл зүйн салбарт сүүлийн жилүүдэд яригдах болсон шинжлэх ухааны сэтгүүл зүйн үйл ажиллагааны үр өгөөжийг нэмэгдүүлэх чиглэлд идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь чухал юм. Олон нийтийн эрэлт хэрэгцээнээс үүдэн шинжлэх ухаан, танин мэдэхүйн сэдэв бүхий нийтлэл, нэвтрүүлгийн ач холбогдол өсөн нэмэгдэж, улмаар түүнд тавигдах шаардлага ч нэмэгдсэн. Тиймээс хэвлэл мэдээллийн хэрэгслүүд нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагынхаа хүрээнд болоод үйл ажиллагааныхаа үндсэн чиг баримжааны дагуу үзэгчдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан бүтээл үйлдвэрлэх нь тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх гарц юм.

Сэтгүүл зүй нь зөвхөн мэдээлэх бус мэдээллийн агуулгаар дамжуулан нийгмийн өнгө төрх, сэтгэлгээг тодорхойлж, түүний өөрчлөлт дэвшилтэд нөлөөлж байдаг онцлогтой салбар. Тэр ч утгаараа шинжлэх ухаан, танин мэдэхүйн бүтээлүүдэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж, чанаржуулах, ач холбогдлыг нь улам нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Эшлэл

1. МХХ. 2015. Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгаа. УБ
2. Зулькафиль М. 2004. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ., х. 80
3. Зулькафиль М. 2020. Шинжлэх ухааны сэтгүүл зүйн онол, практикийн зарим асуудалд “Сэтгүүл зүй” сэтгүүл. УБ., х. 8

4. Максима Консалтинг ХХК. 2020. Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайлан. УБ.
5. Зулькафиль М. 2021. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд боть XVIII, УБ., х. 76.
6. Өнөрсайхан Т. 2022. Телевизийн дүрсэн өгүүлэмжийн илэрхийлэл. Сэтгүүл зүйн үүрэг, нийгмийн хариуцлага, ёс зүй: онол, практик, арга зүй. УБ., х.81
7. Өнөрсайхан Т. 2019. Монголын арилжааны телевизүүд: түүх, онол, арга зүй. УБ., х.111
5. МХХ. 2015. Хэвлэл мэдээлэл хэрэглэгчдийн судалгаа. УБ.
6. Өнөрсайхан Т. 2022. Телевизийн дүрсэн өгүүлэмжийн илэрхийлэл // Сэтгүүл зүйн үүрэг, нийгмийн хариуцлага, ёс зүй: онол, практик, арга зүй (Ред. М.Зулькафиль). УБ.

Summary

In this article, the author explains basic importance of cognitive television program. Television is considered to be an important invention of this century. Nowadays television has evolved so much that it has fundamentally transformed everyone lives. People can watch news, sports various channels also offering series and cognitive and educational programs on science, medicine and so on. Television has succeeded in providing entertainment, excitement and also one of the greatest educator tools. In addition, television programs are considered can influence both individual and socially it's behavior and mental. As we need to increase the quality and quantity of cognitive television programs.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Зулькафиль М. 2004. Сэтгүүл зүйн онолын үндэс. УБ.
2. Зулькафиль М. 2020. Шинжлэх ухааны сэтгүүл зүйн онол, практикийн зарим асуудалд. “Сэтгүүл зүй” сэтгүүл. УБ
3. Зулькафиль М. 2021. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. Боть XVIII. УБ.
4. Максима Консалтинг ХХК. 2020. Телевиз үзэлтийн судалгааны нэгдсэн тайлан.